

ХЗҮХ-ийн захирлын 2011 оны 11.13
дугаар тушаалын 13 дугаар хавсралт



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН НЭРЭМЖИТ ШАТРЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

1. Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийг баталж, Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийг тохиолдуулан жил бүрийн 11 дүгээр сард Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нэрэмжит Шатрын тэмцээнийг зохион явуулна.

Энэхүү тэмцээн нь Хуудь зүйн үндэсний хүрээлэнг олон нийтэд сурталчлах, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, хууль зүйн их, дээд сургуулийн багш, судлаачдын дунд шатрын спортыг түгээн дэлгэрүүлэх зорилготой.

2. Тэмцээнийг тус хүрээлэнгийн Захиргаа, аж ахуйн хэлтэс хариуцан шатрын холбоо, шатар сонирхогч клуб зэрэг байгууллага, хувь хүний дэмжлэг тусlamжтайгаар зохион байгуулна.

4. Тэмцээнд шүүгч, прокурор, өмгөөлөгч ноиариатч, цагдаа, тагнуул, Автгатай тэмцэх газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн ажилтнууд болон хууль зүйн их, дээд сургуулийн багш, судлаачид оролцно.

5. Тэмцээнд шаардагдах зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусгах ба колбогдох зардлын тооцоог гарган Захирлаар батлуулна.

6. Түүнчлэн тус хүрээлэнтэй хамтран ажилладаг болон шатрын спортыг үзмжигч байгууллага, иргэдийн хандив, тусlamжийг авч болно.

7. Сонирхогчдын хандив, тусlamж нь мөнгөн, эд материал болон шагнал гармшууллын хэлбэртэй байж болно. Хандив, тусlamжийг хүлээж авах, зарцуулах эрэг асуудлыг зохион байгуулагч комисс хариуцна.

8. Тэмцээний эхний 3 байр эзэлсэн шатарчдыг шилжин явах цом, үргемжлөл, үнэ бүхий зүйлээр урамшуулна.

9. Мөн Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор профессор Б.Чимидийн нэрэмжит тусгай шагналтай байх ба тусгай шагналыг чадварлаг, уран тогтолт үзүүлсэн оролцогчид олгоно.

-----ooOoo-----